Иймд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Боловсролын чанарын ялгааг арилгах чиглэлээр суралцагчийн тооноос шалтгаалан ээлжийн коэффициент өндөр байгаа ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх замаар ачааллыг бууруулах, нэг багшид ногдох суралцагчийн тоог багасгах, суралцагч хичээлээс гадуур сургуулийн орчинд хөгжих, дугуйлан, бусад хөтөлбөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

* Эх үүсвэр: БШУЯ, Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө, 2021-2030 он.



Хүснэгт 4.10 Ерөнхий боловсролын суралцагчдын анги дэвшилтийн хувь, 2023/2024

I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
99.3	99.3	99.4	99.5	99.5	99.7	98.9	99.4	99.1	83.2	97.9	99.3

Зураг 4.29 Гурван ээлжээр хичээллэдэг сургуулийг хоёр ээлжид оруулах чиглэлээр авч буй арга хэмжээ

2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн зориулалттай түрээсийн байрны мэдээлэл

Чингэлтэй

1 сургуулийн байр /5-р сургууль/

Баянгол дүүрэг

3 сургуулийн байр /141-р сургууль, 28-р сургууль, Оюуны ундраа/

Сонгинохайрхан

5 сургуулийн байр /Өнөр цогцолбор, 62, 12, 122, 42-р сургуулиуд/

Хан-уул дүүрэг

7 сургуулийн байр /15, 18, 52, 115,32, 75, 10-р сургуулиуд/

Баянзүрх дүүрэг

9 сургуулийн байр /120, 44, 30, 53, 91, 21, 111, 14, 14-р сургуулиуд/

Налайх дүүрэг

1 сургуулийн байр /Голомт цогцолбор сургууль/



416 бүлэг 2 ээлжээр 14,985 хүүхэд
/БШУ-ны сайдын 2023 оны А/326, А/349 дүгээр тушаал

Төсөв
2023-2024 оны хичээлийн жилд **7,434.9** сая төгрөг шаардагдана. Үүнээс 2023 оны санхүүгийн жилд **3,130.5** сая төгрөг.



НИЙТ
26 сургууль
26 байр

2022-2023 оны хичээлийн жилд ачаалал өндөртэй, гурван ээлжид шилжих эрсдэлтэй нийт **68 сургууль** үйл ажиллагаа явуулж, **33.0** мянга орчим сурагч суралцаж байсан тул асуудлыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2023 онд "Ерөнхий боловсролын сургуулийн ачааллыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай" **234 дүгээр тогтоолыг баталж**, 2023-2024 оны хичээлийн жилд гурван ээлжид шилжих эрсдэлтэй, ачаалал өндөртэй сургуулиудын асуудлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажилласан.

3 ээлжээр хичээллэх эрсдэлтэй **68** сургуулийн **47** нь Улаанбаатар хотод, **21** нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тул Боловсрол, шинжлэх ухааны яамнаас холбогдох яамд, агентлагуудтай хамтран хөрөнгө оруулалтын ажлуудыг эрчимжүүлэх, түрээсийн зориулалтаар ашиглах барилга байгууламж судлах, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарим төсвийн эх үүсвэрийг шийдвэрлэх, засвар тохижилтын ажлуудыг зохион байгуулах арга хэмжээг шуурхай авч ажиллалаа.

Энэхүү ажлын үр дүнд 2023-2024 оны хичээлийн жилийн эхэнд нийт 60 сургуулийн ачааллыг бууруулж, гурван ээлжээр хичээллэх эрсдлийг арилгаж, **2** ээлжээр шинэ хичээлийн жилд үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлсэн үр дүн гарсан байна.

Харин 2023-2024 оны хичээлийн жилийн эхэнд **8** сургуулийн **64** бүлэгт **2,418** хүүхэд гурван ээлжээр хичээллэж байгаа ба эдгээр сургуулиудын ачааллыг бууруулахад онцгой анхаарч ажиллаж байна.

4.7

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙР

Зураг 4.30 Дотуур байртай сургуулийн тоо, дотуур байрны тоо, 2023/2024



Зураг 4.31 Дотуур байрны хүчин чадал, түүнд амьдарч буй хүүхдийн тоо, 2023/2024




Зураг 4.32 Дотуур байрны тоо, тэдгээрийн стандарт хангалт, 2023/2024



Хүснэгт 4.11 Дотуур байрны хангалтын хувь

	Суралцагчид			Малчдын хүүхэд			Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
	Хүсэлт гаргасан	Амьдарч буй	Дотуур байрны хангалт	Хүсэлт гаргасан	Амьдарч буй	Дотуур байрны хангалт	
2023/2024	37,062	36,029	97	28,845	28,122	97	323
2022/2023	35,616	35,077	98	27,240	26,870	99	376
2021/2022	34,546	32,576	94	26,458	25,169	95	430
2021/2022	34,546	32,576	94	26,458	25,169	95	430

Зураг 4.33 Дотуур байранд амьдарч буй суралцагчид, ангиар, 2023/2024




Зураг 4.34 Дотуур байранд ажиллаж байгаа нийт багш, ажиллагчдын тоо




4.8

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙГ ТӨГСӨГЧИД

Зураг 4.35 Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцаж суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчид




Зураг 4.36 Ерөнхий боловсролын сургуулийг өдрөөр төгсөгчид, боловсролын түвшнээр, 2021/2022



2022-2023 оны хичээлийн жилд ЕБС-ийг нийт **92.7** мянган хүүхэд (9-р ангийг **59.6** мянга, 12-р ангийг **33.1** мянга) өдрөөр суралцан төгссөн нь өмнөх оны хичээлийн жилээс **8.1 (9.5)** мянгаар өссөн байна.

Зураг 4.37 Ерөнхий боловсролын сургуулийн 9 болон 12 дугаар ангийг өдрөөр суралцан төгсөгчид, аймгаар, 2021/2022




Тайлбар: Бусад гэдэгт БНСУ дахь Монгол сургууль, Кембрижийн хөтөлбөрөөр хичээллэж байгаа сургуулиудыг хамруулав.



Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд бага анги төгсөгчдийн бохир жин **98.1** болж өмнөх жилээс **1.6** пунктээр өссөн байна.

Зураг 4.38 Бага анги төгсөлтийн (өдөр) бохир жин, аймгаар, 2021/2022 оны хичээлийн жилд



4.9 ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ

ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫГ ЖИЛД ХОЁР УДАА ЗОХИОН БАЙГУУЛДАГ ТОГТОЛЦООНД ШИЛЖЛЭЭ.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/47 тоот тушаалд “Оюутан элсүүлэх журам”-ын дагуу элсэлтийн ерөнхий шалгалтыг жилд хоёр удаа зохион байгуулах нэмэлт өөрчлөлтийг тусгасан.

Энэ нь шалгуулагч өмнөх шалгалтын дүн оноогоо ахиулах замаар их, дээд сургуульд суралцах боломжийг дэмжиж байгаагаараа онцлогтой.

2023 онд аймгуудын Засаг дарга нартай байгуулсан гэрээнд туссан онцлог ажлын нэг нь “Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил, хамгаалал болон сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас авах улсын шалгалт, чанар болон гүйцэтгэлийн үнэлгээ, ерөнхий боловсролын сургууль төгсөгч, их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авах монгол хэл, бичиг, элсэлтийн ерөнхий шалгалтыг чанартай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх” тухай заалтыг тусгасан байна.

Зураг 4.39 Элсэлтийн ерөнхий шалгалтад орсон хүний тоо, 2023 он



Хүснэгт 4.12 Элсэлтийн ерөнхий шалгалтын статистикийн мэдээлэл, сургуулийн байршлаар, 2022 он

Шалгалтын нэр	Улаанбаатар			Аймгийн төв		
	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д
Англи хэл	10,323	38.9	516	4,771	35.5	504
Биологи	2,068	47.1	513	1,794	51.3	533
Газар зүй	299	48.1	517	123	57.6	567
Математик	9,655	27.9	501	5,806	31.6	524
Монгол улсын түүх	531	35.6	506	140	47.4	567
Монгол хэл	4,423	49.6	497	2,338	54.2	532
Нийгмийн тухай мэдлэг	8,597	41.8	500	4,564	47.2	529
Орос хэл	382	72.0	607	169	65.3	557
Физик	3,568	31.5	501	2,218	36.8	528
Хими	2,139	33.5	517	1,863	34.7	526

Шалгалтын нэр	Сумын төв			Багийн төв		
	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д
Англи хэл	2,773	28.1	468	35	28.8	475
Биологи	1,364	41.8	487	20	33.8	446
Газар зүй	150	47.1	512	2	37.0	471
Математик	3,618	26.6	496	62	24.1	480
Монгол улсын түүх	157	46.1	553	2	30.5	468
Монгол хэл	2,298	51.3	510	34	45.7	468
Нийгмийн тухай мэдлэг	3,363	42.5	503	50	41.1	490
Орос хэл	118	42.8	397	7	40.0	382
Физик	1,518	29.6	492	29	29.8	487
Хими	1,330	26.4	484	20	22.5	454

Хүснэгт 4.13 Элсэлтийн ерөнхий шалгалтын статистикийн мэдээлэл, сургуулийн өмчийн хэлбэрээр, 2022 он

Шалгалтын нэр	Төрийн өмчит сургууль (1779)			Хувийн өмчит сургууль (632)		
	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д
Англи хэл	16,090	34.4	497	1,814	53.8	583
Биологи	4,935	46.5	509	311	57.1	559
Газар зүй	520	48.6	520	54	61.6	584
Математик	17,379	28.1	503	1,764	35.7	546
Монгол улсын түүх	755	38.8	521	75	47.7	568
Монгол хэл	8,704	51.0	508	390	54.5	533
Нийгмийн тухай мэдлэг	15,464	43.0	506	1,111	48.5	538
Орос хэл	562	61.1	528	114	83.9	692
Физик	6,592	31.8	502	742	41.3	550
Хими	4,982	31.4	508	370	42.0	560

Хүснэгт 4.14 Элсэлтийн ерөнхий шалгалтын статистикийн мэдээлэл, хүйсээр, 2022 он

Шалгалтын нэр	Эрэгтэй			Эмэгтэй		
	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д	Ш.Тоо	А.О.Д	Х.О.Д
Англи хэл	8,725	35.8	499	11,097	35.1	501
Биологи	1,299	41.7	483	4,728	45.7	505
Газар зүй	443	44.1	495	360	46.2	506
Математик	10,463	27.6	496	10,649	28.2	504
Монгол улсын түүх	540	35.9	505	674	34.9	497
Монгол хэл	3,440	44.6	460	7,090	52.5	519
Нийгмийн тухай мэдлэг	7,573	38.1	475	11,169	44.9	517
Орос хэл	248	62.7	542	539	61.0	528
Физик	5,746	30.5	494	2,316	34.2	515
Хими	1,383	29.9	494	4,784	30.6	502

Эх үүсвэр: Боловсролын үнэлгээний төвийн статистикийн тайлангийн систем, 2022 он

Тайлбар: 2022 оноос өмнө төгсөгчдийн мэдээлэл хасагдсан болно.

Ш.Тоо - Шалгуулагчийн тоо, А.О.Д - Анхны онооны дундаж, Х.О.Д - Хэмжээст онооны дундаж



Хүснэгт 4.15 Элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан шалгуулагчид, шалгалтын төрлөөр, 2022 он

ШАЛГАЛТЫН НЭР	Нийт шалгуулагчийн тоо	800 оноо авсан шалгуулагчийн тоо	Дүнд эзлэх хувь
Англи хэл	19,822	33	0.17
Биологи	6,027	9	0.15
Газар зүй	803	1	0.12
Математик	21,112	30	0.14
Монгол улсын түүх	1,214	1	0.08
Монгол хэл	10,530	14	0.13
Нийгмийн тухай мэдлэг	18,742	20	0.11
Орос хэл	787	30	3.81
Физик	8,062	11	0.14
Хими	6,167	9	0.15

4.10 АЖИЛЛАГЧИД БОЛОН ҮНДСЭН БАГШ

Зураг 4.40 Ерөнхий боловсролын сургуулийн ажиллагчид, өмчийн хэлбэрээр



Зураг 4.41 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш, өмчийн хэлбэрээр**Зураг 4.42 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш, ангиллаар**

Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажил мэргэжлийн стандартыг боловсруулах ажлын хэсэг (Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/364 дүгээр тушаал)-ээс боловсруулсан стандартын төслийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 3-ны өдрийн 3 дугаар тогтоолоор батлагдлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролын багшийн ажил мэргэжлийн стандарт 2341-01 индексээр, бүрэн дунд боловсролын багш 2330 индексээр бүртгэгдсэн. Багшийн ажил мэргэжлийн стандарт батлагдсанаар багшийн албан тушаалын тодорхойлолт шинэчлэх, багш бэлтгэдэг их, дээд сургуулийн хөтөлбөрийг шинэчлэх, багшийн ажлын норм, нормативыг шинэчлэн тогтоох суурь болох юм.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар Боловсролын багц хуулийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн баталж, 8 сарын 3-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Хууль шинэчлэгдсэнээр гарсан гол өөрчлөлт, шинэчлэлийн нэг нь Багшийн хөгжлийн асуудал байсан. Тодруулбал, Монгол Улсад багш бэлтгэх тогтолцоог шинэчилж, багш мэргэжилтнүүдийг бэлтгэх их дээд сургуулиудад магадлан итгэмжлэгдсэн байх шаардлагыг тависан. Мөн ажлын байран дээр багшийн мэргэжлийн тасралтгүй суралцах, хөгжих боломжийг олгосон явдал юм.

Боловсролын багц хуулийн шинэчлэлийг Монгол Улс анх удаа хийсэнтэй холбогдуулан Монгол Улсын засгийн газраас Боловсролын салбарын реформыг хэрэгжүүлэхдээ багш бэлтгэх тогтолцоонд онцгойлон анхаарч байна. Тодруулбал, багш мэргэжлээр суралцах оюутны сургалтын төлбөрийг энэ хичээлийн жилээс 2030 он хүртэл төр 100 хувь, багш нар дотооддоо магистрт суралцах бол сургалтын төлбөрийг төр 100 хувь хариуцахаар болсны зэрэгцээ МУБИС-ийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөтөлбөрийг шинэчлэх, элсэгчдийн босго оноог өндөрсгөх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Багш бэлтгэх тогтолцоог шинэчилж, багшийн хөгжлийг 2030 он хүртэл бодитой дэмжсэнээр олон улсад өрсөлдөхүйц, эх хэлээ дээдэлсэн, англи хэлний өндөр мэдлэгтэй олон мянган чадварлаг багшийг бэлтгэх юм.


БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ-БАГШИД ЭЭЛТЭЙ БОДЛОГО

Багшийн нийгмийн хамгааллыг сайжруулах, ажлын ачааллыг гүйцэтгэлд тооцох, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахын тулд хувьсах зардлын бүрэлдэхүүнд ангийн хүүхдийн тооноос хамаарсан нэмэгдлийг шинээр тусгаж, багшийн хөгжлийн зардлыг багш бүрээр тооцон олгодог болсон.

Хувьсах зардлын бүрэлдэхүүнд эрүүл мэндийн эрт илрүүлгийн шинжилгээний багцад ороогүй, багшийн ажлын онцлогоос хамаарсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг баталснаар багш нар шинжилгээндээ хамрагдаад байна.




Зураг 4.43 Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалтын хувь




Мэргэжлийн багшийн хангалт 2023-2024 оны хичээлийн жилд 99.5 хувь болж өмнөх оны хичээлийн жилээс 1.8 пунктээр өссөн байна.

Зураг 4.44 Мэргэжлийн багшийн хангалтын хувь, аймгаар, 2023/2024




Зураг 4.45 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувь, 2023/2024



БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖИЛ, АЖЛЫН АЧААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд суурилсан мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны шинэчлэлийг хэрэгжүүлж байна.
- Багшийн хөгжилд багш бэлтгэх их, дээд сургууль, ахмад багш нар, багш нарын мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага гэх мэт олон талын оролцоог хангаж байна.
- Багш нар мэргэжлийн хөгжлийн зардлаа хэрэгцээндээ нийцүүлэн өөрөө зарцуулдаг, сонгож суралцдаг боллоо. 2022-2023 оны хичээлийн жилд хувьсах зардлын **0.6** хувийг мэргэжлийн хөгжилд зориулан зарцуулах боломжтой боллоо.
- Багш үндсэн сургалтаас гадна өөрийн хэрэгцээнд нийцүүлэн модуль сургалтад хамрагдах, ажлын байрандаа мэдлэг, туршлагатай багшаас суралцах, өөрийн туршлагаа түгээн дэлгэрүүлэх боломжоор хангагдаж байна.
- Багшийн ажлын ачааллыг бууруулах, нормыг шинэчлэх хүрээнд багшийн ажил мэргэжлийн стандарт боловсруулж, ажил үүргийн шинжилгээ, ачааллын судалгааг хийлээ.
- Монгол Улсын Засгийн газраас багш бэлтгэх, багшийн тасралтгүй хөгжил, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд багш бүрийг компьютержуулах арга хэмжээг 2024 оноос үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.


Зураг 4.46 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн насны бүлэг, 2023/2024**Зураг 4.47 Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн ажилласан жил, 2023/2024**

Боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан төсвийн шинэчлэл - Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшууллыг олгож эхлээд байна.


Багш нарын цалингийн зэрэглэл, шатлалд өөрчлөлт орууллаа./ Засгийн газрын 2022 оны 107 тоот тогтоол батлагдсан/

- Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээс хамаарч 10-25 хувийн урамшуулалт цалинг сар бүр авах боломжийг бүрдүүллээ.
- Үндсэн цалинг багш нарын ажилласан жилээс үл хамаарахаар тогтоосноор суурь цалин дунджаар 20-34 хувиар нэмэгдэх, багш мэргэжлийн нэр хүндийг өсгөх, нийгмийн баталгааг нь хангах нөхцөл бүрдэж байна.

Зураг 4.48 Нэг багшид ногдох хүүхдийн тоо, 2023/2024



Зураг 4.49 Ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ногдох хүүхдийн тоо



Зураг 4.50 Ерөнхий боловсролын сургуулийн нэг багшид ногдох хүүхдийн тоо , аймгаар, 2023/2024



4.11

БОЛОВСРОЛЫН СЭТГЭЛ ЗҮЙЧ

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/222 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуульд **“БОЛОВСРОЛЫН СЭТГЭЛ ЗҮЙЧ”**-ийг ажиллуулж эхэлсэн.


2023-2024 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 395 сэтгэл зүйч ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байна.



Хүснэгт 4.16 Боловсролын сэтгэл зүйч, аймгаар

Аймаг	2021-2022 оны хичээлийн жил			2022-2023 оны хичээлийн жил			2023-2024 оны хичээлийн жил		
	Сэтгэл зүйчтэй сургууль	Аймгийн төв	Сум	Сэтгэл зүйчтэй сургууль	Аймгийн төв	Сум	Сэтгэл зүйчтэй сургууль	Аймгийн төв	Сум
Архангай	4	2	2	2	1	1	4	2	2
Баян-Өлгий	3	3		1	1		3	1	2
Баянхонгор	1	1		4	2	2	3	2	1
Булган	4	1	3	1	1		3	1	2
Говь-Алтай	3	2	1	4	2	2	1		1
Говьсүмбэр	1	1		1	1		3	2	1
Дархан-Уул	2	2		4	3	1	5	2	3
Дорноговь	2	2		2	1	1	3	2	1
Дорнод				2	2		4	3	1
Дундговь	2	1	1				3	2	1
Завхан	2	2		1	1		3	2	1
Орхон	7	7		10	8	2	6	4	2
Өвөрхангай	2	2		7	4	3	4	2	2
Өмнөговь	1	1		3	2	1	4	3	1
Сүхбаатар				6	4	2	4	2	2
Сэлэнгэ	1	1		2	1	1	5	2	3
Төв				2	1	1	3		3
Увс	7	5	2	1	1		1	1	
Ховд	9	4	5				3	2	1
Хөвсгөл	5	2	3	6	4	2	4	2	2
Хэнтий	4	3	1	3	1	2	3	2	1
Нийт	60	42	18	62	41	21	72	39	33

Зураг 4.51 Боловсролын сэтгэл зүйч, байршлаар



Хүснэгт 4.17 Боловсролын сэтгэл зүйч, дүүргээр

Нийслэл	2021-2022 оны хичээлийн жил	2022-2023 оны хичээлийн жил	2023-2024 оны хичээлийн жил
Багануур дүүрэг	2	2	2
Багахангай дүүрэг		1	1
Баянгол дүүрэг	10	14	12
Баянзурх дүүрэг	14	13	16
Сухбаатар дүүрэг	9	9	12
Налайх дүүрэг	3		1
Хан -Уул дүүрэг	6	9	15
Сонгино хайрхан дүүрэг	9	8	11
Чингэлтэй дүүрэг	2	10	10
Нийт	55	66	80

Зураг 4.52 Боловсролын сэтгэл зүйчийн үйл ажиллагааны үр дүн...



287,386 Монгол Улсын нийт сурагчдын **37.2%** нь сэтгэл зүйн үйлчилгээ авсан байна.

Хүснэгт 4.18 Боловсролын сэтгэл зүйчийн үйл ажиллагааны үр дүн

2023-2024 оны хичээлийн жил	Сурагч	Эцэг эх, асран хамаалагч	Багш, сургуулийн ажилтан	Нийт
Сэтгэл зүйн зөвлөгөө	9,650	2,658	2,307	14,615
Сэтгэл зүйн булгийн зөвлөгөө	24,932	1,506	4,530	30,968
Сэтгэл зүйн сургалт	185,604	41,215	21,005	247,824
Сэтгэл зүйн оношилгоо	67,200	9,306	8,857	85,363
Нийт	287,386	54,685	36,699	378,770

Хүснэгт 4.19 Сэтгэл судлал мэргэжлээр суралцаж байгаа оюутны мэдээлэл

Сургууль	1-р дамжаа	2-р дамжаа	3-р дамжаа	4-р дамжаа	Нийт
Дархан дээд сургууль	20	17	6	18	61
Дорнод их сургууль	12	6	9		27
Дотоод хэргийн их сургууль	6		11	11	28
Их засаг ОУИС	56	82	21	27	186
МУБИС	371	226	171	146	914
МУИС	70	106	134	125	435
МҮИС	20	э	16		39
Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль	47	57	58	52	214
Олон улсын Улаанбаатарын их сургууль	36	55	38	23	152
Отгонтэнгэр их сургууль	28	27	50	8	113
Сити их сургууль	5	6			11
Улаанбаатар эрдэм их сургууль	15	115	8	5	143
Хүмүүнлэгийн ухааны их сургууль	116	103	118	70	407
ШУТИС	16	26	31	23	96
Нийт	818	829	671	508	2,826




4.12

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮДИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

2023-2024 оны хичээлийн жилд "Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага" MNS7005:2023 стандартыг баталж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн орчин нөхцөл, хоолны чанар, аюулгүй байдлыг хангах боломж бүрдлээ.

Зураг 4.53 Үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж буй 1-5 дугаар ангийн нийт суралцагчийн тоо



2023-2024 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн I-V ангийн болон тусгай 6 сургуулийн нийт **382,161** суралцагч үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж байгаа бөгөөд өмнөх оны хичээлийн жилээс **435** суралцагчаар буурсан байна. Энэ нь энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэгчдийн тооны бууралттай холбоотой юм.

Зураг 4.54 Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны хүртээмж, сургуулийн тоо




2023-2024 оны хичээлийн жилд ЕБС-ийн үдийн хоолны газрын хоол үйлдвэрлэлийн захиргааны статистикийн тайлан ирүүлсэн нийт **871** сургуулийн **649 (74.5%)** нь хоолны газартай, **222 (25.5%)** нь хоолны газаргүй байна. Хоолны газартай **649** сургуулийн **501 (77.2%)** нь төрийн өмчийн, **148 (22.8%)** нь хувийн өмчийн сургууль байна. Хоолны газартай **649** сургуулийн **621 (95.7%)** нь нэг хоолны газартай байгаа бол **28 (4.3%)** нь 2-4 хоолны газартай сургууль байна.




Эх үүсвэр: Ерөнхий боловсролын сургуулийн 2018-2021 оны захиргааны статистик мэдээ, 2022-2023 оны хичээлийн жилд 1-5 дугаар ангийн үдийн хоолны үйлчилгээний зохион байгуулалтын мэдээлэл, 2022 оны 10 сарын байдлаар, БШУЯ-ны Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс

Зураг 4.55 Ус цэвэршүүлэгч төхөөрөмжөөр хангагдсан төрийн өмчийн сургуулийн тоо




2021 онд **596** сургуульд **5393** ширхэг ус цэвэршүүлэгч төхөөрөмж шаардлагатай байсан бол 2023 оны байдлаар **172** сургуульд **262** ширхэг ус цэвэршүүлэгч төхөөрөмж нийлүүлснээр **397** сургуульд **5028** ус цэвэршүүлэгч төхөөрөмж шаардлагатай байна. 2023 оны статистикийн мэдээгээр баллонтой **3674**, шугамд холбогдсон **2047** нийт **5721** ус цэвэршүүлэгч төхөөрөмж ерөнхий боловсролын сургуульд 507 сургуульд байна. Төрийн өмчийн **695** сургуулийн **72.9%** нь ус цэвэршүүлэгч төхөөрөмжөөр хангагдаад байна.

Зураг 4.56 Үдийн хоол үйлдвэрлэлийн байрны нөхцөл байдал, сургуулийн тоогоор, 2023-2024



Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн нийт **682** ерөнхий боловсролын сургуульд **821** хоолны газар байна. Нийт хоолны газрын **597 (72.6%)** нь зориулалтын гал тогоотой, **224 (27.2%)** нь зориулалтын бус /анги танхимыг өргөтгөн засварласан, технологи урсгал буруу, шаардлагатай өрөө тасалгаагаар хангагдаагүй, зай талбай бага/, хүчин чадал хүрэлцээгүй гал тогоотой байгаа бол **9 (1.1%)** сургууль нь зориулалтын хоолны газаргүй байна.


Зураг 4.57 Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэлбэр



Улсын хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд төрийн өмчийн нийт **695** ерөнхий боловсролын сургуульд **523** хоолны газар байна. Нийт сургуулийн **323 (46.5%)** нь стандартын гал тогоотой, **372 (53.5%)** нь стандартын бус /анги танхимыг өргөтгөн засварласан, технологи урсгал буруу, шаардлагатай өрөө тасалгаагаар хангагдаагүй, зай талбай бага/ гал тогоотой байгаа бол **120 (17.3%)** сургууль нь түрээсийн хоолны газартай байна.


Эх үүсвэр: ЕБС-ийн хоол үйлдвэрлэлийн орчин нөхцөлийн судалгаа, 2021-2022 оны хичээлийн жил, БШУЯ-ны Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс

Зураг 4.58 Хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хангалт



2023-2024 оны хичээлийн жилд нийт төрийн өмчийн сургуулийн **85.3** хувь нь хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр хангагдаад байна.


Зураг 4.59 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллаж буй ажилтны тоо



Тайлбар: 2023-2024 оны хичээлийн жилийн тогоочийн тоонд зөвхөн ЕБС-ийн мэргэжлийн тогоочийн тоог оруулж тоолсон.

4.13 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ЗҮЙЧ


Зураг 4.60 Хоол зүйчтэй сургууль



“Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай” хууль 2019 онд батлагдаж 2020 оноос эхлэн ерөнхий боловсролын сургууль халуун хоолоор үйлчилж эхэлсэн.


Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтад “Сургуулийн хоол зүйч сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг удирдан зохион байгуулж, суралцагч, ажилтан, эцэг эхэд мэргэжлийн зөвлөгөө өгнө.” гэж тусгасан.

Зураг 4.61 Хоол зүйчийн тоо




“Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль”-д сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг удирдан зохион байгуулах хоол зүйч нь дараах эрх, үүрэгтэй:

1. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зохистой дадал нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;
2. Хоолны цэс боловсруулж, сургуулийн захирлаар батлуулах;
3. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд оролцогчдод мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгөх;
4. Сургуулийн хоол үйлдвэрлэлийн хүнсний хангамжийн талаар сургуулийн захиргаанд захиалга, хүсэлт, шаардлага гаргах;
5. Суралцагчид хооллох зөв дадал, хооллох соёл; тэнцвэртэй хооллолт, шимт бодисын тухай суурь ойлголтыг эзэмшүүлэх;
6. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хянах;
7. Давтан сургалтад хамрагдах.



4.14 НӨХӨН ОЛГОХ ХӨТӨЛБӨРӨӨР* СУРАЛЦАГЧ, ТӨГСӨГЧИД

Зураг 4.62 Нөхөн олгох хөтөлбөрөөр суралцагчдын тоо



Зураг 4.63 Нөхөн олгох хөтөлбөрөөр төгсөгчид, 2022/2023



Хүснэгт 4.8 Нөхөн олгох хөтөлбөрөөр төгсөгчид, аймгаар, боловсролын түвшнээр, 2022/2023

Аймаг	Нөхөн олгох хөтөлбөрөөр төгсөгчид	Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол
Архангай	68	-	28	40
Баян-Өлгий	103	4	42	57
Баянхонгор	147	10	61	76
Булган	46	-	19	27
Говь-Алтай	86	6	37	43
Дорноговь	6	3	3	-
Дорнод	29	8	15	6
Дундговь	16	2	9	5
Завхан	67	3	30	34
Өвөрхангай	95	13	35	47
Өмнөговь	19	9	10	-
Сүхбаатар	47	15	32	-
Сэлэнгэ	95	24	36	35
Төв	85	5	35	45
Увс	147	14	72	61
Ховд	176	6	63	107
Хөвсгөл	96	6	42	48
Хэнтий	18	-	9	9
Дархан-Уул	33	10	21	2
Улаанбаатар	408	60	147	201
Орхон	50	5	15	30
Говьсүмбэр	24	-	10	14

Тайлбар: **Сургуульд элсэх хуулийн насандаа сургуульд ороогүй эсхүл сургууль сурч байгаад завсардсан хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг нөхөн эзэмшүүлэх* хөтөлбөр юм.

4.15

БОЛОВСРОЛЫН ЦАХИМ ШИЛЖИЛТ*

Боловсролын салбарын мэдээллийн системийн багш, ажилтны мэдээлэл солилцох сервисийг ХУР системд байршуулах ажлыг амжилттай хэрэгжүүлсэн жил байлаа. Багш карт, оюутан карт, оюутны автобусны карт захиалах, Оюутан цэрэг-2023, суурь, бүрэн дунд боловсрол, их, дээд боловсролын лавлагаа, суралцаж байгаа тодорхойлолт, нийслэлийн цэцэрлэгт хамрагдах зэрэг үйлчилгээнүүдийг ХУР төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан иргэдэд хүргэж байна.

**БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БҮЙ ОНЦЛОГ АЖЛУУД:**

Боловсролын салбарын мэдээллийн системийн багш, ажилтны мэдээлэл солилцох сервисийг ХУР системд байршуулсан.

Бага, дунд боловсролын статистикийн шинэчлэгдсэн маягтын системийн хөгжүүлэлтийг хийж, 2023-2024 оны хичээлийн жилийн тайланг шинэчилсэн маягтын дагуу боловсруулан гаргасан.

БШУ-ны сайдын 2022 оны “Шаардлага батлах тухай” А/111 дүгээр тушаалаар “Боловсрол сургалтын байгууллагын болон суралцахуйн удирдлагын системд тавих шаардлага /LMS, SMS/”, А/370 дугаар тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээний системд тавих шаардлага”-ыг тус тус баталсан. ТХААГ-аас тус шаардлагад нийцүүлэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж LMS, SMS систем дээр 4, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний систем нийт давхардсан тоогоор 5 аж, ахуйн нэгжтэй ерөнхий гэрээ байгуулснаар дээрх системүүдийг цэцэрлэг, сургууль сонголттойгоор боловсрол, сургалтын үйл ажиллагаанд ашиглаж, ашиглалт, үйлчилгээний зардлыг хувьсах зардлын цахим хэрэглээний зардлаас санхүүжүүлдэг болсон. 2023 оны жилийн эцсийн байдлаар 381 сургууль SMS, LMS-ийг, 21 цэцэрлэг, сургууль хоол үйлдвэрлэл, үйлчилгээний системийг нэвтрүүлэн сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд БСМС-тэй мэдээлэл солилцож байна.

2023-2024 оны хичээлийн жилд Олон улсын хөтөлбөртэй төрийн өмчийн 4-н ерөнхий боловсролын сургуулийн элсэлтийн бүртгэлийг цахимаар зохион байгууллаа.

Боловсрол, сургалтын байгууллагад ашиглагдаж буй сургуулийн удирдлагын систем, сургалтын удирдлагын системтэй мэдээлэл солилцох ажлын хүрээнд 2023 онд 20 орчим сервисийг нэмэлтээр хөгжүүлж, хувийн хэвшлийн компаниудад нийт 40 гаран сервисийн үйлчилгээг гарган мэдээлэл солилцох орчин нөхцлийг бүрдүүлж ажилласан.

Боловсролын салбарт суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, дээд боловсролын сургалтын байгууллага төгссөн тухай дипломын лавлагаа, боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа тухай тодорхойлолт болон ерөнхий боловсролын сургуулийн Улсын шалгалтын нэгдсэн дүнгийн хуулбар, ЭЕШ-ын дүн оноо лавлагаа гэсэн 6 төрлийн лавлагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем буюу E-Mongolia системээр дамжуулан олгож байна. Мөн 2023 онд ХУР систем дээр оюутны болон багшийн сервисийг шинээр байрлуулсан бөгөөд E-Mongolia системийн бичиг баримт хэсэгт оюутны болон багшийн үнэмлэх гардаг болсон. Тус үнэмлэх цахимжсанаар оюутан болон багшид тэдгээрт төрөөс үзүүлж буй тэтгэлэг, хөнгөлөлт, урамшуулал, автобусны карт, төлбөрийн НӨАТ-ын буцаан олголт, багшийн үнэмлэхийн лавлагаа зэрэг үйлчилгээ цахим хэлбэрт шилжсэн. Мөн 8-9 сард E-Mongolia системээр СӨБ, ЕБС-ийн 2023-2024 оны хичээлийн элсэлтийг амжилттай зохион байгуулсан. И-Монгол академи болон ГТСМТ төвтэй хамтран Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1. дүгээр зүйлийн 7 дугаарт заасан БШУЯ-ны олгох зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлээ.

Тайлбар: *Энэ бүлгийн мэдээллийг Боловсролын мэдээллийн технологийн төвийн 2023 оны жилийн эцсийн тайлангаас бэлтгэв.

Зураг 4.64 Боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон сургуулийн тоо, 2023/2024



Зураг 4.65 Боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон сургуулийн барилгын тоо, 2023/2024



ХҮН БҮРД БОЛОВСРОЛЫГ ЦАХИМААР

Монгол Улсын өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч байгаа шилдэг багшийн бэлтгэсэн цахим хичээлийг суралцагч орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршдаа суралцах, цахим контентын нэгдсэн сан бүрдүүлэх зорилго бүхий **MEDLE.MN** сургалтын нэгдсэн платформыг 2021 оноос хойш боловсруулан хөгжүүлж байна.



“MEDLE” цахим сургууль нээгдсэнээр Монгол Улс боловсролын салбарын цахим шилжилтээрээ дахин нэг алхам урагшилж байна. 2023-2024 оны хичээлийн жилийн ахлах ангийн 16-н хичээлийн сонголтыг 10-р ангийн 43094, 11-р ангийн 37668 суралцагч хичээл сонголт хийсэн байна.

Medle.mn-д 2023 оны нийт хандалт, хэрэглээг 2022 онтой харьцуулахад хандалт 14 саяас 21 сая буюу 45.8%, Хэрэглэгчийн тоо 946 мянгаас 1,24 сая буюу 30.7%, хэрэглэгчийн зарцуулах дундаж хугацаа 11.9%-аар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


21 аймаг 9 дүүргийн төрийн өмчийн 475 сургуулийн 10, 11-р ангийн 15265 суралцагч цахимаар 16 хичээлийг судалж, 284 багш ажиллаж байна.

МОНГОЛЫН АНХНЫ ЦАХИМ СУРГУУЛЬ-MEDLE.MN

Дэлхий нийтээр технологийн дэвшлийг ашиглаж буйтай холбоотойгоор сургалтын байгууллагын хэв шинж өөрчлөгдөж байна. Монгол Улсад анх удаа ерөнхий боловсролын цахим сургуулийг хөгжүүлэх эхлэлийг тавилаа.

Энэ бол “Medle” цахим сургууль юм. Хот, хөдөөгийн 10 дугаар ангид суралцаж буй **15,000** орчим суралцагчдад ирээдүйд эзэмших ажил, мэргэжлийн дагуу хичээлээ сонгон цахимаар судлах боломжийг бүрдүүллээ.

Зураг 4.66 "MEDLE" цахим сургуулийн хамрах хүрээ



2023-2024 оны хичээлийн жилд "MEDLE" цахим сургуулийн хамрах хүрээ Нийслэл хотод 119, орон нутаг буюу аймгийн төвүүдэд 114, сумын төвд 234, багт 7, Солонгос улс дахь Монгол сургуульд 1 байна.

Зураг 4.67 "Medle" цахим сургуулийн хичээл сонголт



Зураг 4.68 “Medle” цахим сургуулийн багш



Зураг 4.69 Цахим сургууль 2023-2024 оны хичээлийн жилд



Цахим сургууль 2023-2024 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 10, 11, 12 дугаар ангийн 2250 бүлгийн 45 000 сурагчдад 563 үндсэн багш сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд ирэх жил буюу 2024-2025 оны хичээлийн жилд 45 000 сурагчидтай сургалтын үйл ажиллагаа эрхлэн явуулах болно.

Зураг 4.70 Цахим сургууль 2023-2024 оны хичээлийн жилд багшийн хөгжлийн сургалт



2023-2024 оны хичээлийн жилд Цахим сургуулийн багш бэлтгэх модуль-1,2 сургалтад 2300 багш 4600 цаг, цахим сургуулийн 334 багш 8640 цаг, багшийн цахим ур чадвар дээшлүүлэх 226 платформд суурилсан 128 хосолсон цагийн сургалт зохион байгуулахаар ажиллаж байна.



05

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ



2023 ОНЫ ОЦЛОХ АЖИЛ:

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаар Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийг шинэчлэн батлуулсан.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагаар мэргэжилтэй ажилтан бэлтгэх мэргэжлийн нэр, индекс, сургалтын хөтөлбөрүүдийг Олон Улсын жишигт нийцүүлэх сургалтад Олон Улсын Пийрсон, Эсэл, Коосэний хөтөлбөрүүдийг судлан нэвтрүүлж, мэргэжлийн боловсролын 2.5 жилийн сургалтын хугацааг 3 жил болгож стандарт, хөтөлбөр, агуулгын шинэчлэлийг хэрэгжүүллээ.

БШУ-ны сайдын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/56 дугаар тушаалаар "ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ" зохион байгуулах удирдамж, арга зүйг баталж, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын 69 байгууллагыг чанарын үнэлгээнд хамрууллаа. Салбар дундын 9 чадамжийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан "Цахим үйлчилгээний ажилтан" мэргэжлийн ангиудыг нээж, ялгаатай хэрэгцээ, ур чадварын түвшинг харгалзан сургалтын хөтөлбөрт тохируулга хийж, төгсөгчид суралцсан хугацаанд нь тэтгэлгийг тооцон олгож болох зэргээр тэгш хамруулах тогтолцоог бүрдүүллээ.

2023-2024 оны хичээлийн жилд Pearson ВТЕС хөтөлбөрийг 6 сургууль хэрэгжүүлж байна. Pearson ВТЕС хөтөлбөрөөр 6 сургуульд нийт 314 суралцагч суралцаж байна.

БШУ-ны сайдын 2023 оны А/228 дугаар тушаалаар "Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын мэдээллийн систем"-ийн шинэчлэлт хөгжүүлэлтэд мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Боловсролын багц хуулийн шинэчлэлтэй уялдуулан мэргэжлийн боловсрол болон бүрэн дунд боловсролын хөтөлбөрийг хослуулан эзэмшүүлэх хөтөлбөрийн хугацааг 3 жил болголоо.

ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс, ЮНЕСКО, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) болон Мэргэжлийн боловсрол, сургалт-түншлэл ЮНЕВОК төв хамтран "МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН (МТБС) ҮНДЭСНИЙ ХОЁРДУГААР ФОРУМ"-ЫГ зохион байгууллаа.



Хүснэгт 5.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын үндсэн үзүүлэлт, 2023/2024

Үзүүлэлт	Нийт	Төрийн өмчийн	Хувийн өмчийн
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА			
Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тоо	76	48	28
Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв	40	20	20
Политехник коллеж	33	25	8
Бусад	3	3	-
Үүнээс: Нийслэл	36	13	23
Орон нутаг	40	35	5
СУРАЛЦАГЧ			
Нийт суралцагчид	38,294	26,828	11,466
Үүнээс: эрэгтэй	24,179	17,794	6,385
эмэгтэй	14,115	9,034	5,081
Үүнээс: Нийслэл	19,141	9,305	9,836
Орон нутаг	19,153	17,523	1,630
Техникийн боловсрол	4,460	3,345	1,115
Мэргэжлийн боловсрол	33,468	23,179	10,289
Мэргэжлийн сургалт	366	304	62
Малчин өрхөөс суралцагч	8,816	7,395	1,421
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч	638	446	192
Үүнээс: эрэгтэй	357	243	114
эмэгтэй	281	203	78
Төгсөх ангид суралцагч	20,124	13,576	6,548
Үүнээс: эрэгтэй	11,807	8,476	3,331
эмэгтэй	8,317	5,100	3,217
ШИНЭЭР ЭЛСЭГЧ			
Шинээр элсэгчид	21,199	14,165	7,034
Үүнээс: Эрэгтэй	12,813	9,058	3,755
Эмэгтэй	8,386	5,107	3,279
Үүнээс: Нийслэлд	9,824	4,311	5,513
Орон нутагт	11,375	9,854	1,521
Техникийн боловсрол	1,299	949	350
Мэргэжлийн боловсрол	19,534	12,912	6,622
Мэргэжлийн сургалт	366	304	62
Малчин өрхөөс шинээр элсэгч	4,507	3,503	1,004
БАГШ, АЖИЛТАН			
Нийт багш, ажилтан	4,168	3,434	734
Үүнээс: Эрэгтэй	1,439	1,191	248
Эмэгтэй	2,729	2,243	486
Үүнээс: Нийслэлд	1,562	916	646
Орон нутагт	2,606	2,518	88
Үндсэн багш	2,351	1,914	437
Үүнээс: Эрэгтэй	827	677	150
Эмэгтэй	1,524	1,237	287
Үүнээс: Нийслэлд	1,027	639	388
Орон нутагт	1,324	1,275	49


5.1 МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА



Монгол Улсын хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын түвшинд сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй **76** сургалтын байгууллага байгаагаас сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын **48** буюу **63.2** хувь нь төрийн өмчийн, **28** буюу **36.8** хувь нь хувийн өмчийнх байна.

Зураг 5.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр, дүнд эзлэх хувь




Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас төрийн өмчийн / БШУЯ-ны харьяа/ **37**, төрийн өмчийн их, дээд сургуулийн харьяа **8**, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа **1**, "УБТЗ ХНН"-ийн харьяа **1**, ШШГЕГ-ын харьяа **1**, хувийн өмчийн **29** сургалтын байгууллага 2022-2023 оны хичээлийн жилд сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 5.2 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, хэв шинж, байршлаар

Үзүүлэлт		2021/2022 оны хичээлийн жил			2023/2024 оны хичээлийн жил		
		Нийт	Төрийн өмчийн	Хувийн өмчийн	Нийт	Төрийн өмчийн	Хувийн өмчийн
Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага		75	43	32	76	48	28
Хэв шинж	Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв	44	19	25	40	20	20
	Политехник коллеж	30	23	7	33	25	8
	Бусад	1	1		3	3	-
Байршил	Үүнээс: Нийслэлд	36	10	26	36	13	23
	Орон нутагт	39	33	6	40	35	5

Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас **40** буюу **52.6** хувь нь мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, **33** буюу **43.4** хувь нь политехник коллеж, **3** буюу **4** хувь нь бусад хэв шинж бүхий сургалтын байгууллага байна.

Зураг 5.2 Нийслэл, орон нутаг дахь мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тоо



Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын **40** буюу **52.6** хувь нь орон нутагт, **36** нь буюу **47.4** хувь нь нийслэлд үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 293 дугаар тогтоолоор их, дээд сургуулийн харьяа мэргэжлийн боловсрол, сургалтын 5 байгууллага байгуулагдаж Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/335 дугаар тушаалаар сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. Үүнд:

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяа Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн харьяа Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн харьяа Цэргийн хөгжмийн политехник коллеж

Орхон аймгийн Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн харьяа "Эрдэнэт политехник коллеж"

Монгол Улсын консерваторын харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж

Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон сургалтын байгууллага 2 байна. Үүнд:

"Монголын цогц сургалт хөгжлийн академи" НҮТББ-ын дэргэдэх мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв

Дорноговь аймаг дахь Төмөр замын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв

5.2

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ

БШУ-ны сайдын 2023 оны А/56 дугаар тушаалаар “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээг зохион байгуулах удирдамж, арга зүй”-г баталж, чанарын үнэлгээнд боловсрол, соёл урлаг, цагдаа, батлан хамгаалах онцгой байдлын салбараас бусад мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт зохион байгуулж улсын хэмжээнд өмчийн бүх хэлбэрийн нийт 69 мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг хамруулсан. Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын чанарыг үнэлэх нь суралцагчдыг ажил мэргэжлийн хувьд салбарын стандартад нийцсэн мэргэжилтэн бэлтгэх, эдийн засгийн хөгжлийг дэмжих, насан туршийн суралцахуй, нийгмийн оролцоонд хувь нэмэр оруулахад чухал ач холбогдолтой бөгөөд чанарын үнэлгээний үр дүнд үндэслэн сургуулийн менежментийн чанарыг сайжруулах боломжтой юм.


Мэргэжлийн боловсролын салбарын хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт ихтэй байдаг 8 мэргэжлийн хөтөлбөрийг сонгон чанарын үнэлгээ зохион байгуулсан бөгөөд судалгаанд хамрагдсан 21 аймаг, 8 дүүргийн үр дүнг харууллаа.

Суралцагчдаас авсан бичгийн шалгалтын үр дүнг мэргэжлийн хөтөлбөрөөр задлан шинжилсэн үр дүнг нэгтгэн харууллаа.

Зураг 5.3 Шалгалтын ерөнхий үр дүн, хөтөлбөрөөр




Зураг 5.4 Аймаг, дүүргээр харьцуулсан дүн



Графикаас харахад Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Увс, аймаг, СБД, СХД, ЧД, ХУД, БЗД, Налайх дүүргийн дундаж улсын дунджаас дээгүүр болон ойролцоо үр дүн үзүүлсэн байна. Бусад аймаг, дүүргийн хувьд улсын дунджаас доогуур үзүүлэлттэй шалгагдсан байна.


5.3 МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧ

Зураг 5.5 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт суралцагч, өмчийн хэлбэр, хувиар



Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын **76** байгууллагад 2023-2024 оны хичээлийн жилд **38,294** суралцагч суралцаж байгаагаас **26,828** буюу **70.1** хувь нь төрийн өмчийн, **11,466** буюу **29.9** хувь нь хувийн өмчийн сургалтын байгууллагад суралцаж байна

Зураг 5.6 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч, хүйсээр




Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг хүйсээр авч үзвэл, нийт суралцагчдын **14,115** буюу **36.8** хувийг эмэгтэй, **24,179** буюу **63.2** хувийг эрэгтэй суралцагч эзэлж байна.

Жендерийн тэнцвэрт байдлын индекс буюу **100** эрэгтэй суралцагч тутамд ногдох эмэгтэй суралцагчийн тоо **60** болж өмнөх хичээлийн жилээс **7** пунктээр буурсан байна.





Зураг 5.7 Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын суралцагчдын хүйсийн тэнцвэрт байдлын индекс, хувиар



● Нийт суралцагчдад эмэгтэй суралцагчийн эзлэх хувь ● Хүйсийн тэнцвэрт байдлын индекс

Зураг 5.8 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдын тоо, нутаг дэвсгэрийн байршлаар



Нийт суралцагчийн **19,141** буюу **49.9** хувь нь Улаанбаатар хотын **36** сургалтын байгууллагад, **19,153** буюу **50.1** хувь нь орон нутгийн **40** сургалтын байгууллагад суралцаж байна. Аймаг арав авч үзвэл, 2023-2024 оны хичээлийн жилд хамгийн олон суралцагчтай нь Дархан-Уул аймгийн сургалтын 3 байгууллагад **2,246**, хамгийн цөөн суралцагчтай нь Сүхбаатар аймгийн сургалтын 1 байгууллагад **350** суралцагч суралцаж байна.


Зураг 5.9 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт суралцагчид, сургалтын хэв шинжээр



Хүснэгт 5.3 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, мэргэжлийн салбараар, 2023/2024 оны хичээлийн жилийн эхний хагас жилд

Д/д	Салбар	Мэргэжлийн тоо	Нийт суралцагчид	Үүнээс:			Хувь
				Техникийн боловсрол	Мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт	
1	Боловсрол	2	63	40	23	-	0.2%
2	Соёл, урлаг	30	2821	285	2521	15	7.4%
3	Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдал	15	232	-	232	-	0.6%
4	Санхүү, бизнес, худалдааны	4	530	75	455	-	1.4%
5	Мэдээллийн технологи	13	2511	217	2294	-	6.6%
6	Шуудан, харилцаа холбоо	2	80	-	80	-	0.2%
7	Байгаль орчин, аялал жуулчлал	7	1085	17	1068	-	2.8%
8	Барилга	27	7301	685	6543	73	19.1%
9	Тээвэр	21	4989	1047	3799	143	13.0%
10	Эрчим хүч	8	226	57	169	-	0.6%
11	Уул уурхай	20	2102	258	1844	-	5.5%
12	Хөдөө аж ахуй	16	1619	349	1259	11	4.2%
13	Аж үйлдвэр	40	12043	1299	10635	109	31.4%
14	Хот байгуулалт, тохижуулалт	3	129	-	129	-	0.3%
15	Үйлчилгээ	8	2316	131	2170	15	6.0%
16	Эрүүл мэнд	2	247	-	247	-	0.6%
Дүн		218	38,294	4,460	33,468	366	100.0%


Зураг 5.10 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, мэргэжлийн салбараар, хүйсээр, 2023/2024 оны хичээлийн жилийн эхний хагас жилд



Нийт суралцагчдыг мэргэжлийн салбараар авч үзвэл, 2023-2024 оны хичээлийн жилд хамгийн олон суралцагчтай мэргэжлийн салбаруудаас аж үйлдвэрийн салбарын **40** мэргэжлийг нийт суралцагчдын **31.4** хувь нь, барилгын салбарын **27** мэргэжлийг нийт суралцагчдын **19.1** хувь нь тус тус сонгон суралцаж байгаа бол хамгийн бага суралцагчтай нь боловсролын салбарын **2** мэргэжил, шуудан, харилцаа холбоо мөн адил **2** мэргэжлийг нийт суралцагчдын **0.2** хувь нь тус тус сонгож суралцаж байна.



Зураг 5.11 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, насаар, 2023/2024 оны хичээлийн жилийн эхний хагас жилд



Нийт суралцагчдын 15,588 буюу 40.7 хувийг 14-16, 11,468 буюу 30.0 хувийг 17-20, 2,591 буюу 6.8 хувийг 30-34, 2,218 буюу 5.7 хувийг 25-29, 2,049 буюу 5.4 хувийг 21-24, 2,303 буюу 6.0 хувийг 35-39, 2,076 буюу 5.5 хувийг 40 ба түүнээс дээш насныхан эзэлж байна.

Нийт 38,294 суралцагчаас **18** хүртэлх насны суралцагчид 21,650 байна. **18** хүртэлх насны суралцагчаас хагас өнчин 2,125 буюу нийт суралцагчийн 5.5 хувийг, бүтэн өнчин 182 буюу нийт суралцагчийн 0.5 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 638 суралцагч сурч байгаа нь нийт суралцагчийн 1.6 хувийг эзэлж байна.

Зураг 5.12 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид, тэдгээрийн хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2023/2024 оны хичээлийн жилийн эхний хагас жилд




Шинээр элсэгчид. Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 2023-2024 оны хичээлийн жилийн эхний хагас жилд **21,199** суралцагч шинээр элссэн байна. Нийт шинээр элсэгчдийн **8,386** буюу **39.6** хувь нь эмэгтэй, **12,813** буюу **60.4** хувь нь эрэгтэй байна. Жендерийн тэнцвэрт байдлын индекс буюу **100** эрэгтэй шинээр элсэгч тутамд ногдох эмэгтэй шинээр элсэгчийн тоо **65** байна.

Хүснэгт 5.4 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт элсэгчдийн тоо

Үзүүлэлт	2019/ 2020	2020/ 2021	2021/ 2022	2022/ 2023	2023/ 2024
Нийт шинээр элсэгч	24,853	24,628	25,264	19,256	21,199
Үүнэс: Эмэгтэй	10,396	10,613	11,087	7,779	8,386
Эрэгтэй	14,457	14,015	14,177	11,477	12,813
Шинээр элсэгчдийн дотор тухайн жилд 9-р анги төгсөгчийн тоо	8,435	9,095	7,966	7,827	9,218
Шинээр элсэгчдийн дотор тухайн жилд 12-р анги төгсөгчийн тоо	2,892	2,112	1,575	1,356	2,202
Ажиллагчдаас	3,756	2,363	2,179	1,700	2,319
Ажилгүй иргэдээс	8,829	8,905	11,282	6,677	6,100
Бусад	941	2,153	2,262	1,696	1,360

Зураг 5.13 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын нийт элсэгчид, хүйсээр



Шинээр элсэгчдийн **9,218** буюу **43.5** хувь нь тухайн жилд ерөнхий боловсролын **9** дүгээр ангийг төгссөн суурь боловсрол эзэмшигчээс, **2,202** буюу **10.4** хувь нь тухайн жилд ерөнхий боловсролын **12** дугаар анги төгссөн бүрэн дунд боловсрол эзэмшигчээс, **6,100** буюу **28.8** хувь нь ажилгүй иргэдээс, **2,319** буюу **10.9** хувь нь ажиллагчдаас, **1,360** буюу **6.4** хувь нь бусад хүрээнээс элссэн байна.

2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн нийт төгсөгчдөөс:

- Суурь боловсрол эзэмшсэн нийт **60,372** төгсөгчдийн **9,218** буюу **15.3** хувь нь:
- Бүрэн дунд боловсрол эзэмшсэн нийт **34,078** төгсөгчдийн **2,202** буюу **6.5** хувь нь мэргэжлийн болон



Хүснэгт 5.5 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын шинээр элсэгч, суралцагч, төгсөх ангид суралцагчид, мэргэжлийн салбараар, хүйсээр, 2023/2024 оны хичээлийн жилийн эхний хагас жилд

№	Салбар	Шинээр элсэгчид		Техникийн боловсрол		Мэргэжлийн боловсрол		Мэргэжлийн сургалт	
		Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
1	Боловсрол	16	8	16	8	0	0	0	0
2	Соёл, урлаг	1,085	554	78	36	992	516	15	2
3	Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдал	232	16	0	0	232	16	0	0
4	Санхүү, бизнес, худалдаа	497	368	42	40	455	328	0	0
5	Мэдээллийн технологи	1,466	811	58	16	1,408	795	0	0
6	Шуудан, харилцаа холбоо	40	14	0	0	40	14	0	0
7	Байгаль орчин, аялал жуулчлал	882	477	0	0	882	477	0	0
8	Барилга	3,723	595	138	26	3,512	567	73	2
9	Тээвэр	2,639	564	350	107	2,146	415	143	42
10	Эрчим хүч	113	19	0	0	113	19	0	0
11	Уул уурхай	1,340	244	73	18	1,267	226	0	0
12	Хөдөө аж ахуй	1,208	480	120	32	1,077	438	11	10
13	Аж үйлдвэр	6,365	2,889	387	166	5,869	2,645	109	78
14	Хот байгуулалт, тохижилт	129	79	0	0	129	79	0	0
15	Үйлчилгээ	1,229	1,054	37	33	1,177	1,007	15	14
16	Эрүүл мэнд	235	214	0	0	235	214	0	0
Дүн		21,199	8,386	1,299	482	19,534	7,756	366	148

№	Салбар	Суралцагчид		Техникийн боловсрол		Мэргэжлийн боловсрол		Мэргэжлийн сургалт	
		Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
1	Боловсрол	63	46	40	23	23	23	0	0
2	Соёл, урлаг	2,821	1,453	285	167	2,521	1,284	15	2
3	Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдал	232	16	0	0	232	16	0	0
4	Санхүү, бизнес, худалдаа	530	401	75	72	455	329	0	0
5	Мэдээллийн технологи	2,511	1,375	217	86	2,294	1,289	0	0
6	Шуудан, харилцаа холбоо	80	30	0	0	80	30	0	0
7	Байгаль орчин, аялал жуулчлал	1,085	609	17	10	1,068	599	0	0
8	Барилга	7,301	1,085	685	131	6,543	952	73	0
9	Тээвэр	4,989	735	1,047	268	3,799	425	143	42
10	Эрчим хүч	226	35	57	14	169	21	0	0
11	Уул уурхай	2,102	311	258	67	1,844	244	0	0
12	Хөдөө аж ахуй	1,619	584	349	111	1,259	463	11	10
13	Аж үйлдвэр	12,043	5,126	1,299	621	10,635	4,427	109	78
14	Хот байгуулалт, тохижилт	129	79	0	0	129	79	0	0
15	Үйлчилгээ	2,316	2,011	131	110	2,170	1,887	15	14
16	Эрүүл мэнд	247	219	0	0	247	219	0	14
Дүн		38,294	14,115	4,460	1,680	33,468	12,287	366	160

№	Салбар	Төгсөх ангид суралцагчид		Техникийн боловсрол		Мэргэжлийн боловсрол		Мэргэжлийн сургалт	
		Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм	Бүгд	Эм
1	Боловсрол	38	32	15	9	23	23	0	0
2	Соёл, урлаг	1,048	578	134	98	899	478	15	2
3	Цагдаа, батлан хамгаалах, онцгой байдал	232	16	0	0	232	16	0	0
4	Санхүү, бизнес, худалдаа	480	354	25	25	455	329	0	0
5	Мэдээллийн технологи	1,133	673	130	60	1,003	613	0	0
6	Шуудан, харилцаа холбоо	41	12	0	0	41	12	0	0
7	Байгаль орчин, аялал жуулчлал	848	443	17	10	831	433	0	0
8	Барилга	3,591	630	531	104	2,987	524	73	2
9	Тээвэр	2,639	585	540	130	1,956	413	143	42
10	Эрчим хүч	169	35	57	14	112	21	0	0
11	Уул уурхай	1,319	244	138	28	1,181	216	0	0
12	Хөдөө аж ахуй	1,189	493	102	32	1,076	451	11	10
13	Аж үйлдвэр	5,912	2,970	812	419	4,991	2,473	109	78
14	Хот байгуулалт, тохижилт	129	79	0	0	129	79	0	0
15	Үйлчилгээ	1,120	960	94	77	1,011	869	15	14
16	Эрүүл мэнд	236	213	0	0	236	213	0	0
Дүн		20,124	8,317	2,595	1,006	17,163	7,163	366	148

5.4

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨГЧИД

2022-2023 оны хичээлийн жилд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын **76** байгууллагыг **19,940** суралцагч 16 салбарын **218** мэргэжлээр ур чадвар эзэмшин төгссөн. Төгсөгчдийн **39.6%** буюу **7,902** нь ажлын байртай, **8.6%** буюу 1,710 нь дараагийн шатны боловсролын түвшинд дэвшин суралцсан статистик мэдээ гарсан байна.




Төгсөгчдийн статистик мэдээллийг 2021 оны 07 дугаар сард захиргааны статистик мэдээллээр гарган түүнээс хойш тухайн оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар мөшгөх судалгаа хийгдээгүй бөгөөд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт хэрхэн өөрчлөгдсөн талаарх тоон мэдээллийг цуглуулах шаардлага бий болсон.

Иймд төгсөгчдөөс мэргэжлээрээ ажиллаж байгаа, эзэмшсэн мэргэжлээс өөр ажил эрхэлж байгаа, өөртөө ажлын байр бий болгон ажиллаж байгаа, гадаадад ажил хөдөлмөр эрхэлж байгаа зэрэг хөдөлмөр эрхлэлттэй холбоотой “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2021-2022 оны хичээлийн жилийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-г салбарын бодлого, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх зорилгоор 2023 оны 4-р улиралд зохион байгуулан үр дүнг нэгтгэн дор харууллаа.

Судалгаанд 2021-2022 оны хичээлийн жилд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын **76** байгууллага үйл ажиллагаа явуулж байснаас 2023 оны 12 дугаар сарын байдлаар дээрх сургалтын байгууллагуудаас **4** байгууллага төгсөлт хийгээгүй учир судалгаанд нийт **72** сургалтын байгууллагын **19,681** төгсөгчийг хамруулсан. Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн **14,891** нь хөдөлмөр эрхлэх буюу дараагийн боловсролын түвшинд суралцаж **4,790** нь бусад шалтгаантай /цэрэгт явсан, хүүхдээ хараад гэртээ байгаа, ямар нэгэн тодорхой шалтгаантай, холбоо барих боломжгүй, ажилгүй зэрэг/ байна. Өөрөөр хэлбэл 2021 оны нийт төгсөгчдийн **92.5** хувь нь энэхүү судалгаанд хамрагдсан байна.

Зураг 5.14 2021-2022 оны хичээлийн жилийн төгсөгчид, судалгаанд оролцогчдын тоо



2022 онд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт нь **1** жилийн дараа буюу 2023 оны 12 дугаар сарын байдлаар нийт төгсөгчдийн **69.9** хувь нь хөдөлмөр эрхэлж, **8.5** хувь нь дараагийн боловсролын түвшинд элсэн суралцсан байна. Ийнхүү 2022 оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт өмнөх хичээлийн жилийн хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдөөс **2.9** хувиар өссөн байна.

Зураг 5.15 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2021-2022 оны хичээлийн жилийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, дараагийн боловсролын түвшинд суралцсан төгсөгч /хувиар/



Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь 1 жилийн дараа нэмэгдэх болсон гол шалтгаан нь 2020, 2021 онд цар тахлын халдвар хамгааллын дэглэм, хөл хорионы улмаас аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа зогсож, нэлээдгүй иргэд ажилгүй болж байсан үе байсан. Цар тахлын хөл хорио үе шаттайгаар суларч, цуцлагдсаны дараа аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа жигдэрч, хэвийн горимд шилжсэнээр ажиллагчдын тоо цар тахлын өмнөх түвшинд хүрч нэмэгдсэн байна.

Эх үүсвэр: ХНХЯ, Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2022 оны III улирал


Судалгаанд оролцогч нийт **19,681** төгсөгчөөс **7,814** буюу **39.7** хувь нь мэргэжлээрээ ажиллаж байгаа, **3,825** буюу **19.4** хувь нь эзэмшсэн мэргэжлээс өөр ажил эрхэлж байгаа, **1,308** буюу **6.6** хувь нь өөртөө ажлын байр бий болгон ажиллаж байгаа, **144** буюу **0.7** хувь нь гадаадын улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа, **663** буюу **3.4** хувь нь дээд боловсролд, **837** буюу **4.3** хувь нь техникийн боловсролд, **70** буюу **0.4** хувь нь гадаад улсад боловсрол эзэмшин суралцаж байна.



Хүснэгт 5.6 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2020-2021 оны хичээлийн жилийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, сургалтын байгууллагын өмчийн хэлбэрээр, 2023 оны 12 дугаар сарын байдлаар

